


Дэлхийн өв-ОХСДГ-ын уур амьсгалын судалгаа


1. Агаарын температур, дулааны өөрчлөлт

Хийн мандлын төлөв байдлыг илэрхийлэх гол элемент нь агаарын температур юм. Хийн мандал дахь температурын хуваарилагдалт түүний хувьсал өөрчлөлтийн зүй тогтлыг агаар мандлын дулааны горим гэнэ.

Дэлхийн өв-Орхоны хөндий орчмын агаарын температурын өөрчлөлтийг цаг уурын Бат-Өлзий, Хужирт, Хархорин станц, Хашаат, Хотонт харуулын 1970-2014 оны ажиглалтын мэдээнд үндэслэн гаргалаа.

Бидний судалгаа хийсэн нутгийн жилийн дундаж агаарын температурын явцыг 1970-2014 оны үзүүлэлтээр авч үзэхэд бүх сумдын нутгаар өсөх хандлагатай байна. 1-р зурагт судалгаанд хамрагдсан нутгаар дунджилсан агаарын температурын үзүүлэлтийг авч явц, хандлагыг тодорхойллоо. Дунджилсан үзүүлэлтээр 1970-1990 оны дунджаар жилийн дундаж температур 0.0°C байсан бол 1991-2014 оны дунджаар 0.96°C болж дулаарсан байна.






Зураг 1. Агаарын дундаж температурын өөрчлөлт (20 жилийн хугацаанд)

Харин сумдын нутгаар тусгайлан авч үзэхэд агаарын температурын жилийн дундаж нь 1970-1990 онд -1.8 -аас 0.8°C байсан бол 1991-2014 оны дунджаар 0.4 - 3.3°C -аар тус тус нэмэгдсэн байна. Энэ үр дүнгээс үзэхэд дулааралтын эрчим жилд 0.02 - 0.16°C байсан байна.

Судалгаанд хамрагдсан нутагт 1970-1990 онд дундаж агуурга 34.2°C байсан бол сүүлийн 20 жилд 36.4°C болж 2.2°C -аар нэмэгдсэн нь өвлийн улирлын хүйтрэлтийн тоон утга нь зуны улирлын дулааралтын утгаас давахгүй байгааг илэрхийлэх нэг үзүүлэлт юм.



3

ура
г 2.
Ага
ары
н
үнэ
млэ
хүй


их, бага температур, тэдгээрийн агууригийн явц, хандлага

Агаарын үнэмлэхүй температур +/- 35⁰С болж хэлбэлзэх нь түүхийн дурсгалд эд өлгийн зүйлсийг гэмтээх нөлөөтэй. Зураг 3-аас харахад агаарын үнэмлэхүй их температур өсөх, бага температур буурах хандлагыг үзүүлж байгаа нь температурын хэлбэлзэл дээрх хэмжээнээс хэтрэх нөхцөл ойртож буйг харуулж байна. Тухайлбал 1998, 2010 онд үнэмлэхүй их температур 33.6⁰С, хүрч халсан бол 2010, 2012 онд -38.2⁰С хүрч хүйтэрсэн байна.

2. Хур тунадасны өөрчлөлт, чийгшлийн байдал

Хийн мандлын хур тунадас бол манай орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэх үндсэн хүчин зүйлийн нэг юм.

Судалгаанд хамрагдсан нутгийн жилийн нийлбэр тунадасны дунджийн олон жилийн явцын зургаас харахад жил бүр харилцан адилгүй байна. 1972 онд 99.3 мм, 2014 онд 111 мм буюу хамгийн бага тунадас унасан байгаа нь олон жилийн дунджаас бага тунадастай байна.






Зураг 3. Хур тунадасны өөрчлөлт

Хур тунадасны өөрчлөлтийг олон жилийн дундажтай харьцуулахад Хархорин, Бат-Өлзий, Хашаат, Хужиртад 1.1-78.3 мм хүртэл хэмжээгээр буурсан, Хотонт суманд 20 орчим мм нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Салхи

Газрын гадаргатай харьцангуй хөдөлж байгаа агаарын хэвтээ чиглэлийн урсгалыг салхи гэдэг.

Салхины зонхилох чиглэлийг тодорхойлж үзэхэд баруун хойноос 40, баруунаас 30, зүүн хойноос 14 хувийн давтагдалтай байна.



Зураг 4. Салхины хурдны өөрчлөлт

Дээрх зургаас харахад судалгаанд хамрагдсан нутгуудын 1970-1990 оны хооронд салхины их хурд 10.4-13.9 м/с байв. Харин 1991-2014 оны хооронд 11-18,5 м/ болж, 0.6-4.5 м/с-ээр нэмэгдсэн байна.

Мөн салхины хүчний өөрчлөлтийг тодорхойлоход судалгаанд хамрагдсан нутгуудад харилцан адилгүй байна. Тухайлбал тал хээрийн бүсэд хамрагдах Хашаат, Хархоринд өндөр үзүүлэлттэй байна. Энэ тухайн сумдуудад дулааралт эрчимтэй явагдаж байгааг илтгэж байна.